



for a living planet®

**“Цоохор ирвэсэнд ээлтэй нутаг” төслийн
Тогтвортой хөгжлийн боловсрол бүрэлдэхүүн
хэсгийн хүрээнд хийгдсэн 2 дахь удаагийн сургалтын тайлан**

2008 оны 11 сарын 25-аас 11 сарын 29 хүртэл Ховд аймгийн төв, Манхан, Зэрэг, Дарви, Чандмань сумын сургуулиудын удирдлага, багш нарыг хамруулан сургууль төвтэй 2 дахь удаагийн сургалтыг хийлээ. Сургалт явуулсан багт МУИС-ийн МДССТ-ийн аргазүйч багш Б.Батцэцэг, Ховд аймгийн БСГ-ын БУ-ы мэргэжилтэн Б.Сайнсанаа, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Алтай-Соёны бүсийн салбарын боловсролын асуудал хариуцсан ажилтан Л.Алтанцэцэг, төслийн туслах ажилтан П.Магсаржав, жолооч Ш.Гантулга нар ажиллалаа.

Энэ удаагийн сургалтаар

- *Өмнөх сургалтын дараа сургууль тус бүрийн боловсруулан туршиж заасан хичээлийн хөтөлбөрт бусад багш нараар нь анализ хийлгүүлж, мөн төслийн сургагч багш нарын зүгээс хэрхэн сайжруулах талаар зөвлөмж өгөх*
- *ТХБ-ыг эзэмшүүлэхэд янз бүрийн талуудын эрх ашиг, сонирхолыг харгалзан үзэхийн ач холбогдол, онцлог*
- *ТХБ-ын асуудлыг бага ангийн хичээлийн хөтөлбөртэй хэрхэн уялдуулах боломж байгааг **Алим** сэдвийн жишээн дээр тайлбарлах*
- *Өмнөх сургалтаар гаргасан гарын авлага, тэдгээрийг багш нар хэрхэн ашиглаж байгаа болон үүнтэй холбоотой тулгарч буй бэрхшээл (өөрөөр хэлбэл гарын авлагын ач холбогдлыг үнэлэх)*
- *Хүүхдийн жижиг бизнес эрхлэх боломж, энэ талаар сурагчдын гаргаж буй санал санаачлага, эдгээртэй холбоотой багш нарын санал гэсэн агуулгыг хамран багаар хийж гүйцэтгэх дасгал ажил, харилцан санал солилцох болон бусад сургалтын заах аргуудыг ашиглан явууллаа.*

1-р даалгаварын зорилго, ач холбогдол (Хичээлийн хөтөлбөрт анализ хийх): Багш нар өөрсдийн болон бусад багш нарын боловсруулсан хичээлийн хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийж алдаа оноон дээрээ суралцах, хөтөлбөрөө улам сайжруулах боломжийг олгоход оршиж байсан.

2-р даалгаварын зорилго, ач холбогдол (Дэлхийн тунхаглал гарын авлага): Энэ ажлын гол зорилго нь өмнөх сургалтаар өгсөн гарын авлагыг багш нар хэр бие даан ашиглах боломжтой байгаа, мөн уншиж судлан хичээлдээ ашигласан зэргийг үнэлэх, ашиглалттай холбоотой гарч буй хүндрэлийг тодорхойлох, зөвлөмж өгөхөд оршиж байсан.

3-р даалгаварын зорилго, ач холбогдол (Талуудын ашиг сонирхол): Тогтвортой хөгжилд нийгмийн янз бүрийн талууд, тэдгээрийн ашиг сонирхол ихээхэн чухал байдаг. Үүнтэй холбоотой юмыг олон талаас нь харж зөв шийдвэр гаргах чадварыг сурагчдад багаас нь эзэмшүүлэх зайлшгүй

шаардлага урган гарч байгаа. Энэ бүхнийг багш нарт ойлгуулах, хичээлтэй хэрхэн холбох боломж байгааг харуулах зорилготой.

4-р даалгаварын зорилго, ач холбогдол (ТХ-ийн тулгуур асуудлуудын хоорондын уялдаа холбоог харуулсан зохиомж бичих): Бидний амьдралд тохиолдож буй аливаа асуудлууд байгаль, нийгэм, эдийн засгийн нягт уялдаа холбоон дээр тогтож байдаг. Өнгөц харахад нийгмийн асуудал мэт байвч түүний цаана эдийн засгаас хамааралтай, үгүй бол байгаль экологт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн, эсвэл хамааралтай байх нь олонтоо. Энэ уялдаа холбоог өөрсдийн бодит амьдрал дээрх жишээн дээр гаргаж ирэх зорилготой.

2008 оны 11 сарын 25. Манхан сумын бүрэн дунд сургууль

Сургуулийн удирдлага, багш нарыг хамарсан нийт 46 хүн сургалтанд хамрагдлаа.

Батцэцэг: Та бүхний өмнөх сургалтын дараа хийж гүйцэтгэсэн даалгавар бол ТХБ-ын асуудлуудыг тусгасан хичээлийн хөтөлбөр боловсруулж турших явдал байсан. Манхан сумын сургуулийн хувьд хэд хэдэн хөтөлбөр явуулсан. Төслийн баг та нарын боловсруулсан хөтөлбөрт анализ хийсэн. Үүнийгээ танилцуулах болно. Гэхдээ үүнээс өмнө та бүхэн багаар ажиллана уу.

Даалгавар 1: Багш нар 5 багт хуваагдаж өөрсдийн боловсруулсан Ус, усны бохирдол сэдэвт хичээлийн хөтөлбөрт дараах шалгууруудын дагуу өөрсдөө анализ хийх (хугацаа 30 мин)

- Энэ сэдвийг аль хичээл дээр хэдэн цаг авч үзэхээр боловсруулсан байна бэ?
- Сэдвийн хөтөлбөрийг боловсруулахдаа ямар элементүүдийг сонгон авч тэдгээрийг хэрхэн тодорхойлсон байна вэ?
- Математик, биологи, физик, эрүүл мэнд, газарзүй, түүх г.м хичээлүүд тс бүртээ өөрийн батлагдсан хөтөлбөрийн дагуу хэрэгжиж байгаа. Энэ хөтөлбөрүүдийн агуулгатай тухайн сэдвийн агуулга хэрхэн холбогдож байна вэ?
- Хичээлийн зорилго болон зорилтуудыг хэр оновчтой тодорхойлсон байна вэ?
- Уг сэдвийг ЭЗ, эколог, нийгмийн асуудлуудын уялдаа холбоон дээр авч үзэж чадсан байна уу?
- Уг сэдэв тухайн ангийн сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирч байна уу?
- Хөтөлбөрт тусгагдсан агуулга арга зүй нь зорилгоо биелүүлэхэд хүрэлцээтэй байж чадаж байна уу?
- Энэ хөтөлбөрийн хүрээнд сурагчид ба багш ямар үйл ажиллагаа явуулсны дүнд ус, усны найрлага, усны төлөв байдал, усны бохирдолтын талаар өөртөө ямар мэдлэгийг бүтээж, багш ямар орчин бүрдүүлсэн бэ?
- Энэ хөтөлбөрийг бодит амьдралд хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарч байна вэ?

- Энэ бэрхшээлийг давахын тулд сургуулийн хэмжээнд ямар зохицуулалт, шийдвэр гаргах нь зүйтэй вэ?

I баг (Найман шарга): БУ-ы нэгдмэл хичээлээр 10-11 ангиудад 1 цагаар заасан бөгөөд хичээл хоорондын интеграцийн хувьд хими, эрүүл мэнд, математик, физик, газарзүй, биологи зэрэг хичээлтэй холбоотой товч мэдээлэл өгсөн байна. Энэ сэдвийн хувьд зорилго, зорилтоо тодорхойлсон. Экологийн асуудлуудыг нилээд сайн тусгасан, харин нийгмийн болон эдийн засгийн асуудал тодорхойгүй. Зарим зорилтууд (3,4-р), агуулгын хувьд тухайн ангийн сурагчдад арай хөнгөдсөн байна. Аргагүйн хувьд боломжийн байсан.

Бэрхшээл: хичээл заах-усны (далай тэнгисийн г.м усыг батлах жишнээ байхгүй) ялгааг гаргахад, амьдрал дээр хими, физикийн арга хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй.

Зохицуулалт: лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах, нийт сурагчид, ард иргэд, багш нар, эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулах

II баг: Хугацааны хувьд 1 цагийн хичээлээр заахад арай багадсан гэж үзэж байна. Эрүүл мэнд, түүхийн хичээлтэй төдийлөн холбогдож чадаагүй. Агуулгын хувьд онолын талыг илүү тусгасан. Өөрөөр хэлбэл хэрэглээ талаас нь бага анхаарсан байна.

III баг: Усны үнэ цэнийг ойлгуулах тал дээр агуулгад оруулж өгөх байжээ.

IV баг (Яаж ч мэдэх найм): хугацаа арай бага байна. Хичээлийн алхамуудын нарийн хугацааг нь тавьж өгөөгүй. Усыг бохирдохоос хэрхэн урьдчилан сэргийлэх талаар их агуулга оруулсан бол зүгээр байлаа. Мөн багшийн төлөвлөсөн арга тодорхой бус байна.

V баг: Хугацааг 3-4 цаг болгон онол, туршилт, практик дадлага гэсэн байдлаар хувааж авч үзвэл хүүхдэд өгөжтэй, хичээл хоорондын интеграц сайн тодорч өгөх байсан болов уу. Маш ойрхон гол байгаа тул практик туршилт хийх бүрэн боломжтой.

Батцэцэг: Арга зүйн хувьд буюу багш ямар үйл ажиллагаа, сурагчид ямар үйл ажиллагаа хийх вэ гэдэг нь тодорхойгүй байсан. Мөн цогц чадамжууд (K1, K2, K3, K4)-уудыг заахдаа оновчтой бус, 1 хичээлээр эзэмшүүлэх боломжгүй тохиолдолд хүртэл бэлэгдлийн чанартайгаар оруулж ирсэн байсан.

Даалгавар 2: Дэлхийн тунхаглалын зарчмуудыг өөрийн үгээр (хүүхдэд ойлгомжтой байдлаар) илэрхийлэх

Хэлний мэргэжлийн багш нарын баг: Амьдрах орчин гэсэн сэдэв ордог. Энд хот хөдөөний ялгаа, түүний давуу ба сул талыг гаргаж өгч болох юм. Байгальдаа ойр хөдөөгийн амьдрал, хүмүүсийн эвдрээгүй зан чанарыг харуулсан Сэгс цагаан богд найраглалаар харуулж, хотын амьдрал байгалаас хол боловч соёл боловсролдоо ойр, мөн амьдралын өртөгийн ялгаа, сэтгэл зүйн хувьд хот хөдөөгийн ялгаа, стресс, гэмт хэрэг гэх мэт.

Алтанцэцэг: Энэ гарын авлага нь шууд Дэлхийн тунхаглал гэдэг хичээл орохыг бус харин энд байгаа тогтвортой хөгжлийн үзэл санааны агуулгыг өөрсдийн зааж буй хичээлийн онцлогт тааруулан хэрхэн шигтгэж болох

боломжтой гэдгийг багш нарт санал болгож байгаа юм. Мөн багш нар маань гарын авлагаа өнгөрсөн хугацаанд хэр өөрийн болгож чадсан, цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлох гэсэн зорилгоор энэ дасгал ажлыг хийлгэсэн юм. Одоогийн байдлаар тийм ч хангалттай бус байгаа нь харагдаж байна.

Даалгавар 3: Талуудын ашиг сонирхол (Алимын мод, алим тариалагч, алим худалдан авагч зэрэг өөр сонирхолтой талуудын ашиг сонирхолыг бичих)

Алимын мод: намайг арчлах цэцэрлэгч хэрэгтэй. Байгаль экологийн хувьд надад тохиромжтой сайхан нөхцөл бүрдсэн байх ёстой.

Алим тариалагч: Амтат алимаа хурааж зах зээлд борлуулах зорилготой. Үүний тулд модоо сонгохдоо байгаль цаг ууртаа тохирсон ургах чадвартай сортыг сонгох шаардлагатай. Сибирь сортын алимын модыг тарих арчлах аргазүйг ярив (алим ургах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах.).

Алим худалдагч: Маш хурдан зарах тал дээр анхаарч сурталчилгааг сайн хийнэ. Ингэхдээ чанар, нэр төрлийн хувьд аль болох худалдан авагчийн сонирхолыг татахуйц байлгахыг хүснэ.

Амин дэмээр баялаг

Ашиг тус ихтэй

Амтат алимаа аваарай г.м

Даалгавар 4: Зохиомж бичих (ТХ-ийн тулгуур асуудлуудын хоорондын уялдаа холбоог харуулах)

Аж ахуй эрхлэлт, ядуурал, газар ашиглалт: Монгол орон социалист нийгмээс зах зээлийн нийгэмд шилжсэнтэй холбоотой олон албан газар үүдээ хааж **ажилгүйдэл, ядуурал** нилээд газар авч амьдрахад нилээд бэрхшээлтэй болж ирлээ. Энэ үед толгойд цаашид яаж амьдрах вэ гэсэн бодол намайг эзэмдэж эхэллээ. Удаан бодсоны эцэст **жимс жимсгэний аж ахуй эрхлэх санаа төрж** багахан хэмжээний газар авч алим тарьж эхэллээ. Арчилж тордож асар их хөдөлмөрлөсний үр дүнд амтат сайхан алим ургаж ашиг орлого маань ч нэмэгдлээ.

Хэдэн жил санаа зовох зүйлгүй амьдарч байтал авах үр жимс багасаж ашиг орлого хумигдах боллоо. Учрыг нь тунгаавал **өнөөдөр авах ашгаа бодож байснаас биш хөрс байгаль дэлхийгээ бодохгүй явж** Алтыг нь аваад авдрыг нь хаяв гээч л болж дээ гэдгийг хожим ухаарсан юм даа.

Тээвэрлэлт, ядуурал, хортон шавьж: Монгол орон зах зээлийн тогтолцоонд шилжсэнээр дотоодын үйлдвэрлэлээ орхиж бэлэнчилж гадаад зах зээлээс чанартай чанаргүй янз бүрийн хүнсний зүйл тээвэрлэх болов. Энэ бүхнээс Батын аав ч хоцорсонгүй. Банкнаас өндөр хүүтэй их хэмжээний зээл авч Эрээн хот руу алимны наймаанд явлаа. Банкнаас авсан мөнгөөрөө баахан алим бөөндөж аваад чингэлэг дүүрэн алимтай эх орноо зорилоо. Буцаж эрээд алимаа худалдан борлуулах ажилдаа ханцуй шамлан орлоо. **Буруу тээвэрлэлт, буруу хадгалалтын улмаас өнөөх алим өт хорхойд идэгдэж** муудаж эхлэв. Улмаар муудсан алимыг авах худалдан авагчид цөөрч харин банкны хүү өдрөөс өдөрт нэмэгдэж өр гэдэг үстэй толгойноос

ихэдлээ. **Банкны хүүний оронд байдаг зүйлээ өгсөн Батын аав** их санасан газар 9 шөнө хоосон гэгчийн үлгэрээр **Монгол орны ядуусын тоог нэгээр нэмжээ.** Эндээс тэр ихийг ухаарч айлаас эрэхээр авдраа уудал гэдэг үгийг санаж өөрийн эх орны хөрсөнд алим тарьж эхлэв. Алимны модыг өдөр бүр арчилж ургуулсаар өөрийн гэсэн эдлэн газар, эд хөрөнгөтэй болж өөдлөн дэвжихийн их үүд нээгдлээ. Эндээс эх орны хөрс хичнээн эрүүл, хишиг хичнээн их юм бэ гэдгийг ойлгож үр хүүхдүүд хойч үедээ өвлүүлэн үлдээж гэнэ.

Тээвэрлэлт, бордоо, эрүүл мэнд: Нэгэн сургуулийн багш Жаргалмаа ажлаа тарж явах зуураа хүнсний зах оров. Тэндээс маш сайхан өнгө үзэмж сайтай, хямдхан, том алим худалдан авч гэрийн зүг их л баяртай явлаа.

...24 цагийн дараа...гэр бүлийн хүмүүс бүгд хордсон байв. **Эмнэлэгт үзүүлж ар араас нь бөөн ажил ундрал. Учир явдлыг ч тодруулжээ. Хүнсний эрүүл ахуйч Мэндбаяр зах дээр зарагдаж буй алиманд шинжилгээ хийхэд дараах дүгнэлт гарлаа. Үүнд фермерийн эзэн Тулгаа алимны модоо зөвшөөрөгдөөгүй химийн бордоогоор бордож, тэрхүү химийн бордоогоор томорсон алимыг наймаачин Цогзолмаа ашгаа бодож жолооч Бямбасүрэнгийн түлш бага хэрэглэдэг, удаан явдаг машинд ачин олон хоног тээвэрлэн ирсэн байна. Улмаар хэтэрхий реклам хэрэглэж борлуулалтаа сайн хийж худалдав.**

МХА-ы байцаагчийн дүгнэлт: багш Жаргалмаагийн гэр бүлийн эмчилгээнд зарцуулсан зардал 350000 төгрөгийг бизнесмен Цогзолмаа гаргасугай, тээвэрлэлтийн горим зөрчсөн жолооч Бямбасүрэнгийн жолоодох эрхийг 3 сараар хассугай. Зөвшөөрөгдөөгүй химийн бордоог ашигласан Тулгаагийн аж ахуй эрхлэх үйл ажиллагааг зогсоож олсон ашгийг улсын орлого болгосугай.

МХА-ы байцаагч Мэндбаяр.

2008 оны 11 сарын 26. Зэрэг сумын бүрэн дунд сургууль

Сургуулийн удирдлага, багш нарыг хамарсан нийт 38 хүн сургалтанд хамрагдсан.

Даалгавар 1. Хичээлийн хөтөлбөрт анализ хийх

Усны дээж оргих булаг” хичээлийн хөтөлбөр

I баг: бүх хичээлтэй холбосон (хими, биологи, эрүүл мэнд, газарзүй, математик, түүх, уран зохиол). ЭЗ, экологи, ниймийн асуудлуудыг цогц байдлаар нь хамарсан. 8-р ангийн сурагчдын нас, сэтгэхүйд тохирсон, хугацааны хувьд боломжтой. Бэрхшээл: хүмүүст таниулах, тэдний сэтгэхүйг өөрчлөх, хамгаалалтыг улам сайжруулахтай холбоотой ажил хийх шаардлагатай. Үүнтэй холбоотой хөрөнгө санхүүгийн бэрхшээл гарч байна.

II баг: багаар ажиллах аргазүйг хэрэглэсэн. Усны нөөц, хэрэглээ, зөв зохистой ашиглах, хамгаалалт, цаашид рашаан хэлбэрээр хэрэглэх гэсэн чиглэлээр хичээлийг явуулсан нь ТХ-ын тулгуур 3 ойлголтыг оруулж чадсан гэж үзэж байна.

III баг: “Цэвэр усны нөөц хомсдож байгаатай холбогдуулан усыг зөв зохистой ашиглах хамгаалах” –тай холбоотой хичээлээ явуулсан.

IV баг: Монголд 2-хон байдаг онцлог рашааныг хайрлан хамгаалж авч үлдэх сэтгэлгээг хүүхдүүдэд олгох зорилготой хичээл байсан. Энэ зорилгодоо тодорхой хэмжээгээр хүрсэн гэж үзэж байна. Хичээлийг явуулахад тулгарсан бэрхшээл гэвэл манай суманд хичнээн ширгэсэн булаг, шанд байдаг талаар мэдээлэл олдохгүй байсан. Энэ бэрхшээлийг арилгах хамгийн энгийн арга зам бол багш нар хүүхдүүдтэйгээ хамтарч судалгаа хийх явдал юм.

Даалгавар 2. *Дэлхийн тунхаглал гэж юу вэ? Дэлхийн тунхаглал, тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол гурвын хоорондын уялдаа холбоог хэлнэ үү. Энэ сургалтын авлага багш нарт сургалтын ямар арга зүйг санал болгож байна вэ? өөрөөр хэлбэл ТХБ-ыг эзэмшүүлэхэд хамгийн их хэрэглэгдэх, үр дүнтэй байж болох арга нь ямар арга вэ?* гэсэн чиглэлээр багш нартай харилцан ярилцаж санал солилцлоо.

Даалгавар 3: Талуудын ашиг сонирхол

Алимны мод: Би алимны мод билээ. Миний дээр маш сайхан алимнууд ургаж хүн бүхэн идэхийг хүсдэг. Хүн бүрийн тэр хүслийг хангахын тулд би маш сайхан ургах ёстой. Гэхдээ би бусдын дэмжлэггүйгээр сайхан ургаж чадахгүй. Сайхан сэтгэлтэй хүмүүс намайг арчилж торддог. Гэтэл гэнэн томоогүй нь мөчрийг минь гэмтээгээд биеийг минь ихээхэн өвтгөдөг. Намайг өвдсөн үед ургасан алимны чанар мууддаг. Муудсан алим идсэн хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг. Үүнийг мэдсэн хүмүүс дахиж алимны модыг гэмтээхгүйг мэдэж намайг тордож ургуулдаг болсон. Би алимны мод болж төрсөндөө бахархдаг. цагаад гэвэл алимныхаа үр жимсээр олон түмнийг тэжээж тэтгэдэг юм. **(маш сайхан алимтай баймаар байна, үүний тулд хэн нэгэн намайг тордох ёстой).**

Алим тариалагч: Манай алимны хүлэмж нь олон төрлмийн мод ргадаг. Бид амьдралаа дээшлүүлэхэд зориулан алимныхаа модыг байнга арчлан хамгаалж байдаг. Сайн чанарын арвин ургац авуухын тлд хөрс болон модондоо анхаарал тавьдаг. Мөн хүмүүсийг эрүүл жимсээр ханагхын тулд анхаарч ажилладаг. Тийм ч учраас манай нийлүүлэгчид сэтгэл хангалуун байдаг. Энэ утгаараа бидний амьдрал өөдрөг хангалуун сайн сайхан байдаг. **(алим ихээр тарих)**

Алим худалдагч: Намайг Алимаа гэдэг. Би алим зарж амьдардаг. Би өөр төрлийн бизнес эрхэлж болх байсан ч хүүхдүүд хүмүүс алим их авдаг тул надад ашигтай санагдсан юм. цагаад гэвэл хүмүүс алимыг ширхэгээр авдаг бөгөөд тэр нь миний бизнесийн эргэлтийг хурдасгаж би их ашиг олох боломжтой гэсэн санаа төрсний учир би алимны худалдаачин болсон. Алимны худалдаачинд бэрхшээл их. Гэвч би шантарсангүй. Алимаа ширхэглэн зарсаар овоо мөнгөтэй боллоо. Супермаркет ч байгуулах боломжтой болсон байлаа. Харин ойрдоо алим гүйхгүй наймаа зогсох гээд байна. Яагаад гэвэл алим жимснээс шар өвчин гарлаа. Одоо би яах вэ? **(их ашиг олох)**

Алим худалдан авагч: Худалдан авагч би эрүүл хөрсөнд тарьж ургуулсан шүүслэнг, амттай, зөв хадгалагдсан, хөлдөж гэмтээгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, үнэ өртөг тохирсон алим худалдан авч хэрэглэхийг хүсдэг. (**хямд үнэ, өндөр чанар**)

Батцэцэг: Алим сэдвийг бага ангийн хичээлүүдэд заахад ямар ямар агуулгыг аль хичээлээр олгож болохыг тайлбарлалаа. Мөн зураг, түүх, хүн байгаль зэрэг хичээл дээр ямар арга зүйгээр яаж авч үзэж болох талаар зөвлөмж өгсөн.

2008 оны 11 сарын 27. Дарви сумын бүрэн дунд сургууль

Сургуулийн удирдлага, багш нарыг хамарсан нийт 29 хүн сургалтанд хамрагдсан.

Даалгавар 1. Хичээлийн хөтөлбөрт анализ хийх:

А. Мэдээлэл хүлээж авах

I баг: 5-р ангид орсон. ЭЗ-ийн талаас түүхий эдийн ханш, нийгэм талаас телевизийн реклам, экологийн талаас агаарын бохирдол, ой, амьтан, усны талаар тулгамдсан асуудлуудыг оруулсан.

II баг: Мэдээлэл зүйн ээлжит хичээлээр заасан. Хүүхэд мэдрэхүйн 5 эрхтэнээрээ мэдээлэл хүлээж авдаг. Ийм учраас математикийн хичээлээр орсон. Зорилго: Хүний өдөр тутмын амьдралд мэдээ мэдээллийн ач холбогдолын талаар оновчтой тодорхойлох. Интеграци: МХ-Хорон санаат хүчлийн үүл гэдэг номыг гэрийн даалгавараар уншуулж, хичээлийн явцад дараах чиглэлээр мэдээлэл өгсөн. ЭЗ-хөгжил, экологи-нөхөн сэргээлт, зураг-үйл явдлын зураг, мат-21 зуун бол мэдээллийн эрин зуун, хүн байгаль-утаагүй орчин, байгалийг цэвэршүүлэх

Батцэцэг: Энэ хичээлээр хүүхэд ямар цогц чадамжуудыг эзэмших вэ?, түүнийг ямар үйл ажиллагаагаар бүтээлгэж, шалгах вэ гэдэг нь тодорхой байвал зүйтэй.

Сайнсанаа: Сэдвийн хувьд 5-р ангийн хүүхдэд арай томдсон агуулгатай байсан болов уу. Тогтвортой хөгжлийн нийгэм талыг илүү тусгасан. Та нарын явуулсан хөтөлбөрийг уншаад шууд анализ хийхэд хэцүү байлаа. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн хэллэг хүнд, үйл ажиллагаагаа тодорхой бус бичиж явуулсантай холбоотой.

Б. Агаарын бохирдол

III баг: 10-р ангид БУНХ-ээр 1 цаг заасан. Хичээлийн төлөвлөлтөн дээрээ интеграцаа тусгаагүй. Гэхдээ тухайн сэдэв бусад хичээл, ШУ-ы агуулгатай тодорхой хэмжээгээр холбогдсон байна. Зорилго, зорилтын тодорхойлсон байдал солигдсон талтай. Энэ хичээл сурагчдад мэдлэг бүтээх тал дээрээ арай дутмаг байсан болов уу.

IV баг: Хэдэн цагаар орохоо хөтөлбөртөө тусгаж өгөөгүй. Хичээл хоорондын залгамж холбоо байгаагүй. Интеграцичлалын хувьд бусад хичээлтэй уялдсан. Нас сэтгэхүй, агуулгын онцлогт тохироогүй. Онол талаасаа илүү хичээл болсон, практик үйл ажиллагаа багатай байв. Мөн орон нутгийн

хүрээнд жишээ баримтаа авах байдлаар агуулгаа орон нутгийн түвшинд авч үзсэн бол илүү үр дүнтэй байх байсан.

Батцэцэг: - 1. Багийн нэртэй холбоотой ажиглалт судалгаа хийх гэсэн ажил байсан нь ямар үйл ажиллагаа байсан бэ? Дэнсмаа: унших материал дээр ажиллаад хүүхдүүд өөрсдөө дүгнэлт хийсэн.

- 2. 10-р ангийн түвшинд хичээлийг илүү үр дүнтэй бодит судалгаан дээр түшиглэсэн байдлаар хүүхдүүдээр шийдвэр гаргах түвшинд явуулбал илүү үр дүнтэй байж болно.
- Бидэнд явуулсан энэ хичээлийн хөтөлбөрт хүүхдүүдээр хийлгэх үйл ажиллагаагаа нилээд сайн тусгасан байсан.

Даалгавар 2. Талуудын ашиг сонирхол

Алимнын мод: Модлог ургамал дотроос алимнын мод болсондоо маш их баярладаг. Яагаад гэвэл хүн бүхний дуртай алим жимс надаас ургадаг. Иймд намайг бүхнээс илүү хайрлах хэрэгтэй.

Хурын ус байхгүй бол

Хувьхан бие минь яах билээ.

Хувьтай төрсөн надад

Хувь заяа байна.

Алимнын мод намайг

Арвижуулан олшруулбал

Арвин их ургац өгч

Амьдралыг тань тэтгэнэ.

Алим тариалагч: Ажил маань өөрийн амттай. Энэ амтыг би хөрс, мод хоёроос хайрлан ургуулдаг. Тариалангийн газрын хөрс маань шимтэй, эрүүл өргөн уудам, хүний болоод байгалийн сөрөг нөлөөнөөс хол байдаг. Харин мод маань үндэс сайтай, мөчир ихтэй саглагар сайхан байдагт би баярладаг. Модонд ургагч алим маань эрүүл, амтлаг, шүүслэг, сорт төрөл ихтэй, технологи сайтай байдаг тул би ажлаараа бахархдаг.

Алимнын худалдаачин:

Амтлаг сайхан улаан шар алимнуудыг

Авч зарахын тулд

Алимнын тариаланчтай

Аятайхан харьцаж

Жимсний зах дээр очиж

Жигтэйхэн их орилж

Алимаа борлуулах нь

Алимнын худалдаачин миний

Амьдралын үнэ цэнэ билээ.

Тийм ээ, би алим зардаг

Тамхи зарж хүмүүсийг хордуулахгүй

Амин дэм ихтэй алим жимсийг

Авч идэж амтлаарай хүмүүс ээ.

Арааны шүлс гоожим амттайхан

Алагхан бондгор алимнуудыг

Алимнын худалдаачин би

Арчилж тордож худалдаалж байна.

Үнэ өртөг багатай
Үнэхээр амтлаг алим шүү
Хоёрыг авбал нэгийг
Хорийг авбал арвыг үнэгүй өгнө шүү
Шүүслэг улаан алимнуудыг
Ширхэг ширхэгээр авч идвэл
Шинэ жилийн баяраа
Шижгэр амжилтаар угтана шүү

Алим худалдан авагч: Алим бол хүний эрүүл мэндэд маш тустай бүтээгдэхүүн юм. Хүн өдөрт дор хаяж 1-2 ш алим заавал идэж байх нь гоо сайхан болон эрүүл амьдрахад тустай юм. Иймээс бидний худалдан авч байгаа алим нь цэвэр байгалийн гаралтай байх нь чухал. Мөн зүй зохистой хадгалагдсан, эрүүл ахуйн шаардлага хангасан, элдэв гэмтэлгүй хөгцөрч муудаагүй, өөрийн эрхгүй түүнийг амтлах сэтгэлгээг хүн бүрт төрүүлэхүйц гайхамшигтай өнгөлөг байх аваас хэрэглэгч бид түүнийг үнэ хайрлалгүй авах болно.

Хараад хазаад авмаар
Хамгийн гоё алим
Худалдан авагч бид нар
Хэзээд авахад бэлэн.

Даалгавар 4. Зохиомж бичих (ТХ-ийн тулгуур асуудлуудын хоорондын уялдаа холбоог харуулах)

А. Алим сэдвийг заах үед зураг ашиглан зохиомж бичих

Б. Алим сэдвийг байгаль, нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлуудтай холбох, өөрөөр хэлбэл өнөө үед амьдрал дээр байгаа бодит жишээн дээр тулгуурлан зургаар илэрхийл.

Импорт, бордоо, хүний эрх: Хятад улсаас импортолж буй алим нь хадгалалт муу, азот калийн бордоогоор бордсон байдаг нь хүний эрүүл аюулгүй амьдрах эрхийг их зөрчиж байна.

Аж ахуй эрхлэлт, эрүүл мэнд, хортон шавьж: Монгол хөрсөнд алим аажуу ахуй эрхэлж тэрхүү эрүүл алим хэрэглэснээс эрүүл монгол хүн өсөж бойжно.

Бүтээгдэхүүний чанар, эрүүл мэнд, хортон шавьж: чанартай чанаргүй алим зураг, эрүүл хүн инээмсэглэнэ, хортон шавьжинд идэгдсэн идэгдээгүй алим зургаар илэрхийлсэн.

2008 оны 11 сарын 28. Чандмань сумын бүрэн дунд сургууль

Сургуулийн удирдлага, багш нарыг хамарсан нийт 32 хүн сургалтанд хамрагдсан. Сургалт эхлэхэд **Л. Алтанцэцэг:** “Тогтвортой хөгжлийн үзэл санааг анги танхимд хэрэгжүүлэх нь” гарын авлагын талаар багш нартай ярилцаж, тэднийг сургалтандаа яаж ашигласан, тулгарсан бэрхшээл байгаа эсэх талаар ярилцав. Үндсэндээ 2 багш л тодорхой хэмжээгээр уншиж танилцсан байлаа. Үүнд:

Багш Ханджав: Монгол хэл уран зохиолын хичээл дээр туршиж үзсэн. Энэ номыг ашиглах боломжтой гэж үзэж байна. Хичээл тус бүрээр бичсэн байсан, тэндээс өөрийн зааж буй хичээлтэй холбоотой хэсгийг ашигласан.

Багш С.Барсүрэн: Эрүүл мэндийн хичээл дээр арьсанд үзүүлэх гоо сайхан сэдвийг заахдаа ТХ-ийн үзэл санааг тусгахыг оролдсон. Ингэхдээ Дэлхийн тунхаглалын 16 зарчмыг уншаад хичээлтэйгээ холбож болох хэмжээгээр нь холбосон.

Ихэнх багш нар гарын авлагатай танилцаагүй, сургалтандаа ашиглаж ойлгож чадаагүй байна. Иймд уг номыг ямар арга зүйгээр сургалтандаа ашиглаж болох талаар дахин заавар зөвлөгөө, аргачлал өгч харилцан ярилцлаа. Мөн тэдэнд дараагийн сургалт хүртэл дахин уншиж танилцах даалгавар өглөө.

Үүний дараа хүүхдүүдийн бизнес эрхлэх төслийн талаар ярилцаж энэ санааг багш нар сурагчдадаа ямар түвшинд хүргэсэн, юу хийсэн талаар ярилцахад:

Багш С.Барсүрэн: 10-р ангийн хүүхдүүдтэй ярилцаж 500 мянган төгрөгт багтаж төсөл бичсэн. Гэхдээ хүүхдүүд мөнгө их шаардагдах юм байна, мөн төсөл бичих гэхээр эдийн засгийн талын асуудлыг сайн мэдэхгүй байна гэсэн бэрхшээл хэлж байсан. Ийм учраас энэ талаар тэдэнд зөвлөгөө өгмөөр байна.

Багш Борхүү: 9 хүүхдийн бүрэлдэхүүнтэй баг гар урлалын зүйл хийх сонирхолтой байгаа. Та нартай уулзуулж заавар зөвлөгөө авах хүсэлтэй байгаа. Одоо ирж уулзана.

Багш Жавзан: Түрүүчийн сургалтын дараа би хүүхдүүддээ байгаль орчноо хайрлан хамгаалах талаар яриа таниулга хийсэн. Үүнээс үүдэн манай 3б ангийн хүүхдүүд гэсэн сайн дурын байгаль хамгаалагч болох сонирхолтой, сэтгэл тэмүүлэлтэй идэвхтэй анги хамт олон байна. Тэднийг чухам яаж удирдаж ямар зохион байгуулалт хийх, ямар үйл ажиллагаа явуулах талаар зөвлөгөө авах шаардлагатай байна.

Алтанцэцэг: 1. Цоохор ирвэсэнд ээлтэй нутаг төслийн хүрээнд хүүхдийн бизнес эрхлэх төсөл хэрэгжүүлэх талаар эхлээд хүүхдийн санал санаачлага хэрэгтэй байгаа юм. Танай сургууль дээр ганц нэг гэлтгүй санал санаачлага байгаа нь сайшаалтай. Хөдөөгийн хөгжлийн ажилтаны хамт удахгүй ирж тэдгээр хүүхдүүдтэй уулзах шаардлагатай юм. Тэр үеэр эдийн засаг болоод бусад асуудлын (бизнес гэж юу вэ, хэрхэн яаж амжилтанд хүрэх вэ, төсөл яаж бичиж боловсруулах вэ г.м) талаар сайтар зөвлөгөө өгч, сургалт хийх болно.

2. Хүүхдүүд байгаль орчноо хамгаалах үйлсэд яаж оролцох, тэдэнтэй хэрхэн ажиллах талаар танай сургалтаас гадуур уулзаж санал солилцож болно. Мөн танай сургуулийн багш С.Барсүрэн, Хос Алтайн ирээдүйн эзэд байгаль хамгаалах клубын зарим сурагчид Ховд, Увс аймгийн хүүхдийн клубуудын уулзалт-сургалтанд оролцож байсан. Та бүхэн эхний ээлжинд эдгээр багш, сурагчидтай хамтарч ажиллаж болох юм.

Даалгавар 1. Хичээлийн хөтөлбөрт анализ хийх

Багш нарын боловсруулсан хичээлийн хөтөлбөрт анализ хийх бүлгийн ажил хийлгэлээ. Багш нарыг дөрөв багт хувааж хийсэн хөтөлбөрийг нь тараан өгч тодорхой шалгуурын дагуу анализ хийлгэж бусдадаа танилцлаж харилцан ярилцав. Ингэхдээ эхлээд багш нараар өөрсдөөр нь алдааг гаргуулж харилцан ярилцаж яаж сайжруулах талаар зөвлөгөө өгөв.

Ургамлын бүтэц:

1-р баг: 3-р ангид заасан. Зорилго, зорилтоо дэвшүүлэхдээ бага зэргийн алдаа гаргасан байна. Хичээл явуулах алхамууд, багшийн болон хүүхдийн үйл нь боломжийн байсан. Гэхдээ үг хэллэг, асуултын хэлбэр нь хүүхдийн нас сэтгэхүйн хувьд арай хүнд байна. Агуулга баялаг тул цагийн хувьд задлаж 2-3 орчим цаг заахаар байна. Сэдэлжүүлэх арга нь аятайхан болжээ. Орон нутгийн тулгамдсан асуудлыг холбож өгсөн, хус мод г.м, харин нэмээд булаг шандтай холбож оруулсан бол зүгээр байлаа. Хүүхэд мэдлэгээ хэрэглээ болгох талаасаа бие дааж судалгаа хийх үйл ажиллагаа оруулж өгсөн бол илүү сайн болох байлаа. 2-р даалгавараас хойш дандаа асуулт маягаар явуулсан. 4-р даалгавар дуу дуулуулах байсан нь ач холбогдлын хувьд багатай үйл ажиллагаа юм.

2-р баг: Тухайн хичээлийн хувьд элемент нь нэгж хичээлийн хүрээнд сонгож авчээ. Даалгаваруудын томъёолол муу байлаа. Мэдлэгийг бүтээх ажлын хуудас муу гарсан.

Хог хаягдал:

1-р баг: Газарзүйн хичээлээр 7-р ангид оржээ. К1-хог, түүний хор уршиг, К2-дахин боловсруулах, цэвэр орчин бүрдүүлэх, К3-эрсдлээс эрүүл мэндээ хамгаалах,

Интеграцчилалын хувьд биологи, эрүүл мэнд, зураг, дуу, МХУЗ, биеийн тамир, математик г.м сайн гаргасан байсан. Хичээлийн орчинг сайн бүрдүүлсэн. Тооцоо судалгаа гаргасан. Дадлаа, туршилтын ажил дутмаг байлаа. Агуулга их тул хугацааны хувьд 3 цагаар заахаар байна. К2-г эзэмшүүлэхдээ тоглох, ярилцах, сонсох, тооцоолох, цэвэрлэгээ хийх, сурталчилгаа хийх, мэдээлэл цуглуулах, зурах, бүтээх арга замаар хийж болох байсан. Сонгосон асуудал нь ТХ-ийн асуудлыг хөндсөн байна. Харин орон нутгийн тулгамдсан асуудал, бодит байдалтай уялдуулж өгвөл сайн болох байсан.

Даалгавар 2. Талуудын ашиг сонирхол

4 багт хувааж алимны мод, алимны худалдаачин, алим тариалагч, алим худалдан авагч гэсэн 4 хэсэг болгож тус тусын ашиг сонирхолыг илэрхийлэх даалгавар өгөв.

Алимны мод: би бусдаас өндөр байж бусдыг харахыг хүсдэг. Мөн хүмүүсийн шүлс асгарам амтат улаан алимтай байхыг хүсдэг. Алимныг минь авахдаа иш үндэс навч хурууг минь бүү гэмтээгээсэй. Миний амьдрах орчин ус, агаар, хөрс, нар, гэрэл дулаан, таатай байхыг хүсдэг. Би их олон найз нөхөдтэй байхыг хүсдэг. Би хөгжмийн яруу эгшигийг сонсох бүрдээ аз жаргалтай байж улам цэцэглэн хөгждөг. Мөн би хүмүүст амьдралын гэгээн аялгууг бэлэглэдэг. Би жилийн дөрвөн улиралд жимстэй байж ургаж цэцэглэхийг хүсдэг. Би олон салаа мөчиртэйдээ бахархдаг. Амьдраад байх

тусам амттай байдаг. Худалдаачид хугацаанаас минь өмнө авчих гээд байх юм. Би өөрийн Монгол сортоороо байхыг хүсдэг.

Алим тариалагч: Би бол алим тариалагч. Би их алим таривал

1. өөрт ашигтай
2. хүмүүст хэрэгтэй
3. эрүүл мэндэд хэрэгтэй
4. эдийн засагт ашигтай
5. байгальд ашигтай

Тариалагч нь зөв сорт буюу чанартай их хэмжээний ургац өгдөг алимны мод сонгоно. Үүний дараа талбай, хөрс, байгаль, ургамалд хор нөлөөгүй бордоо сонгоно. Хамгийн гол нь авч буй ургац маань хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй, биологийн цэвэр бүтээгдэхүүн байх нь чухал юм. Мөн байнгын арчилгаа тордлого ч хэрэгтэй.

Алимны худалдаачин:

Үзэмж сайтай алимыг тээвэрлэлтийн өртөг бага, үнэ нь 2-3 нугарах боломжтой, цаг хугацааны хувьд богино хугацаанд түргэн эргэлттэй, жижиглэнгээр буюу ширхэгээр зарж ашиг олмоор байна. Иймд би алим тариалагчаас аль болох олон жижиг хэмжээтэй алим нийлүүлэх, худалдан авагчид маань ихэвчлэн хүүхэд байдаг тул тэд аль болох олуулаа, бутархай мөнгө ихтэй байгаасай гэж хүсэж байна.

Алим худалдан авагч: Би тариалахдаа аль болох бага бордсон, хадгалалт, амт чанар сайтай, үнэ багатай алим худалдаж авмаар байна.

Даалгавар 3. Алим сэдвээр зохиомж бичих:

1. Эрт дээр үед биш эдүгээ цагийн эхэнд
Энгүй их алимтай
Эрхэмсэг нэгэн мод
Ихэмсэгээр оршиж байжээ.
Арааны шүлс аснгарам
Амтат тэр алимыг гайт нэгэн үүл
Газрын гаваас гарч ирэн
Хөөрхий тэр алимыг хөсөр унаган хаяжээ
Бохирдмсон тэр алимыг
Бодлогогүй хүү Болдоо
Болгоомжгүйгээр идэж орхилоо.
Дотор гэдэс нь өвдөөд
Доктор Догсомд үзүүлж гэнэ.
Доорх зөвлөмжийг авч гэнэ.
Арчиж угааж цэвэрлэсэн
Аюулгүй хүнс хэрэглэж сур
Амь насанд өлзийтэй.

2. Бат 22 настай. Тэр тодорхой эрхэлсэн ажилгүй. Гэвч өдөр хоног өнгөрсөөр амьдрал нь хэцүүдэж өөрийн эрхгүй хөдөлмөрлөх шаардлагатай боллоо. Бодож бодож тэр алим тариалагч болохоор шийдэж маш сайхан үржил шимтэй хөрсөнд сорт сайтай алим тарив. Алим нь үр өгөөжөө өгч

амьдрал нь ч өөр болжээ. Тэрээр хөдөлмөрийн амт гэж үнэхээр гайхамшигтайг мэдрэв. Нэгэн өдөр гэнэтийн зүйл болж өнөөх сайыхан алимны модыг нь ширүүн салхи юу ч үлдээлгүй аваад явлаа. Дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болов. Энэ үеэс эхлэн алимны сагс нь хоосорч амьдрал ахуй нь доошилж авгай хүүхэд нь өлсөж амь зуухад хэцүү болов. Ядарсан ч ямбаа алдахгүй гэгчээр байгалийн гамшгаас болж устаж үгүй болсон өнөөх сайхан модоо дахин сэргээж тарихаар боллоо. Тэрээр хуучин амжилтандаа хүрэхэд тийм ч амар биш байлаа. Уйгагүй хөдөлмөрлөсний эцэст өнөөх мод нь цэцэглэж хашаа дүүрэн жимсний модтой таваг дүүрэн алимтай ам чөлөөгүй, гар завгүй час улаан алимаа шимтэн идэж ширхэглэн зарж суух болов. Ээ дээ, эзэн хичээвэл заяа хичээдэг юм байна шүү.

3. А. Алимны мод байж гэнэ.

Айхтар том алимтай гэнэ.

Аймшигт эрсдлүүдтэй учирч гэнэ

Адагт нь тэр мөхөж

Алдаг сав нь хоосорч гэнэ.

Алимны модыг хамгаалснаар

Аяга таваг нь дүүрлээ

Айлын бяцхан үрс

Амтат алимаа идэцгээлээ.

Б. Хүүхдийн хүсэл:

Хүүхэд бидний дуртай

Хөөрхөн улаан алим

Хөрст дэлхийгээс ургаж

Хүүхдүүд бидний гар дээр ирдэг дээ.

Байгалийн гамшиг

Балагт нэгний уршиг

Газрын гаваас ирэх вий

Хөтлийн цаанаас хүрээд ирэх вий.

Хүүхэд бидний хүслэн

Хоосон сагсны мөрөөдөл

Ээ та минь,

Аман дотор шүлс асгаруулам

Амттай улаан алимныхаа модыг хамгаалъя

Хашаа хайс баръя

Халамж анхаарал тавъя

Хүссэн бүхнээ биелүүлэхэд

Хүүхэд бидний оролцоо чухал шүү

Нэгдэж бид нар чадвал

Нийлбэр дүн нь сагс дүүрэн алим

Хөөр баяр дүүрэн

Хүсэл мөрөөдлөөр дүүрэн

Хүүхэд багачууд бидний алиманд

Хумхын тоос бүү хүрэг.

4. Уулзах, Алзахгүй хоёр эх орны эрдэнэт хөрс дээр алимны мод суулгаж сайхан амилж байтал шороон шуурганы дайралт, шуналт ховдог Бат хоёрын дайсагналд өртөж тэр жил ургац авсангүй. Ингээд хайс хамгаалалт хийсний үр дүнд гоё сайхан алимаар сагсаа дүүргээд ургацын баяраа урамтай гэгч нь тэмдэглэж суугаа Уулзах, Алзахгүй хоёрын үр хүүхдүүд нь Алим дуугаар мэндчилгээ дэвшүүлнэ.

Даалгавар 4. Зохиомж бичих (ТХ-ийн тулгуур асуудлуудын хоорондын уялдаа холбоог харуулах)

Татвар, усны нөөц, хүний эрх: Алимны аж ахуй эрхлэхэд ус, газрын хөрс гол тулгуур юм. Иймд усны нөөцийг зохистой ашиглаж аж ахуй эрхлээд олсон ашгаасаа татвараа төлдөг. Мөн чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадвал хүний амьд явах, эрүүл хүнс хэрэглэх эрхийг хангаж чадах юм.

Тээвэрлэлт, аюулгүй байдал, бордоо: Аюулгүй, чанартай алим хэрэглэхийн тулд зориулалтын техникээр зөв тээвэрлэх, химийн бордоогоор аль болох бага бордсон байх нь зүйтэй.

Татвар, эрүүл мэнд, бордоо: Гаалиар татвар багатай химийн бордоо их орж ирж байгаа нь эргээд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Чанартай бүтээгдэхүүн, эрүүл мэнд, хортон шавьж: Хүний эрүүл мэндэд аюулгүй чанартай алим ургуулахын тулд тариалангийн талбайг хортон шавьжаас ангижруулах хэрэгтэй. Үүний тулд химийн бодис пестицид ашиглаж болох ч байгалийн аргаар хортон шавьжтай тэмцэх аргыг ашиглах нь илүү үр дүнтэй байна.

Батцэцэг: Алим сэдвийг бага ангийн жишээн дээр хэрхэн заах талаар зөвлөмж санаа өглөө. Зураг, хөдөлмөр, биологи г.м

Дараагийн сургалт хүртэл хийх үйл ажиллагаа:

1. Манхан, Зэрэг сумдын сургууль дээр хийсэн сургалтын үеэр багш нар Тогтвортой хөгжлийн үзэл санааг анги тэнхимд хэрэгжүүлэх нь (Дэлхийн тунхаглал) гарын авлагыг төдийлөн уншиж хичээлд ашиглаагүй болох нь ажиглагдсан юм. Энэ байдал Дарви сумын сургууль дээр мөн давтагдсан тул Дарви, Чандмань сумуудад хийсэн сургалтуудад уг гарын авлагатай холбоотой хийх байсан дасгалыг ажиллуулаагүй бөгөөд харин *Дэлхийн тунхаглал гэж юу вэ? дэлхийн тунхаглал, тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол гурвын хоорондын уялдаа холбоо, энэ сургалтын авлага багш нарт сургалтын ямар арга зүйг санал болгож байгаа буюу өөрөөр хэлбэл ТХБ-ыг эзэмшүүлэхэд хамгийн их хэрэглэгдэх, үр дүнтэй байж болох арга нь ямар арга вэ* гэдэг талаар багш нартай харилцан ярилцсан. Мөн дараагийн сургалт хүртэл гарын авлагатай нарийвчлан танилцаж туршиж үзэх; гарсан үр дүн, тулгарсан бэрхшээл зэрэг туршлагаа хуваалцахаар тохирлоо.

2. Загвар сургуулиуд өмнө боловсруулсан хичээлийн хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээн дээрээ үндэслэн улам сайжруулаад төслийн багт 12 сарын 20 гэхэд илгээнэ.
3. Сургуулиуд ТХБ-ын Үндэсний хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэх загвар болж байгаагийн хувьд ирэх 6 сар хүртэл сургалтын болон бусад(практик)

**Report from the project “Land of Snowleopard”(ESD component)
Follow-up training for pilot school teachers (November 24-28th, 2008)**

The training was conducted for whole school teachers of 4 pilot schools of Zereg, Darvi, Mankhan and Chandmani sum through 24th-28th of November.

The training was conducted jointly by B.Battsetseg(MNU), B.Sainsanaa(Khovd aimag Edu dep), and L.Altantsetseg(WWF).

The aim of the follow-up training was to improve teachers' knowledge and skills for integrating ESD into simple lesson curriculum.

Basically the training focused on the followings. Here,

- **analysis of lesson curricula.**
- **exercises concerned on the interests and values of different groups which is an important issue in teaching ESD**
- **exercises on how to integrate SD issues into elementary class curriculum** (an example of teaching a topic *Apple*)
- **follow-up activities concerned to the handbooks provided during previous training** (*Testing ESD (Earth charter) in the classroom etc.*)
- **small-scale business initiatives by students at Mankhan and Chandmani schools**

1. At the end of previous training teachers of the pilot schools decided to develop curricula by teams and test them at lessons and send it to the project team by the end of October. The themes were locally facing problems.

One of the purpose of the second training was to improve those curricula. So before Battsetseg and Sainsanaa gave their comment and advice on the curricula for improvement, the teachers were asked to make analysis on the curricula themselves. At each school teachers worked on their own curricula again and discussed.

The most successfully developed curriculum was from Zereg school. The school managers organized a small competition among teachers. They divided teachers into groups and each group chose different problems. The best curriculum was about a mineral water spring which is only one of two springs in Mongolia that come from sand. The specific of this lesson was that it focused mostly on developing students' critical thinking skill.

Other curricula were mostly informative and fact-based. They include different scientific facts at one lesson that build students' cognitive competence. Teachers mostly focus on word **integration**. To build other competences (creative etc.) for ESD more cooperation of teachers and more wide approach is needed. So Battsetseg and Sainsanaa mentioned it in their comment and the exercises of this seminar were focused on it.

2. Another purpose of this training was to evaluate how useful the handbooks can be in reality, to clarify the facing difficulties when teachers use them and to consider for further materials if needs.

We have discussed with teachers how they have been using handbooks in their subjects since last seminar and figured out that only some of the teachers (at each school there was same situation) had read and tested at few lessons and most said nothing.

So we did small exercises on how to use Earth charter handbook and asked teachers to study it carefully again because this handbook can help teachers to teach SD in the classroom.

3. One of the project objectives is to link RD and ESD issues and test it at Mankhan and Chandmani sum school. In conjunction with this objective there are several activities are planned one of which is to support youth entrepreneurship projects.

At first seminar Staffan gave information about successful business to teachers of Chandmani and Mankhan school. The purpose was to have teachers and students practice what is sustainable development through youth entrepreneurship.

So this time in two schools we met teachers and students who have business initiatives. In Mankhan sum a technology teacher and a group of girls want to run wool processing business. They showed us what had done: wool slippers and socks of different size, cotton bags for shopping, ropes made of plastic bag waste. Their goal is to make people aware about reusing waste and also to develop themselves.

The technology teacher, Mrs.Tomorchorodor, said that she had talked to the head of kindergarten about providing children with wool slippers and showed her the students' works. The head was very positive and hopes on a nice cooperation in the future.

4. On November 24th we met Mr.Khash-Erdene, head of Education department, and discussed about the project. He expressed that WWF Mongolia is supporting new trend at Mongolian education system for many years and its ESD projects are bringing a lot of significance. He also said that Mrs.Sainsanaa was in previous project and is almost expert in ESD among Education department methodologists. So he hopes that she will be more responsible and can show big support to successful implementation of the project representing Aimag Education Department.

Follow-up activities:

1. Teachers and leaders of the pilot schools will do the following activities until the next seminar
 - To improve their curricula based on the analysis by themselves and project team and send by the end of December to the team. The purpose is to share these curricula with other teachers of Mongolia through Green school newsletter and also they can be published as a handbook. Responsible: teachers
 - To develop a curriculum on theme of *Snowleopard and its conservation*. This curriculum aims to touch all aspects (ecological, cultural and economical) that are concerned with this species. It's not an hour or two hour lesson curriculum. It can be taught through several hours and is like a program or theme plan. Responsible: school manager and leaders of teachers' unit
 - To be in touch with Mrs.Sainsanaa every month and share information about what is done in that month in a school. Responsible: school manager
 - To develop school plan for ESD until June of 2009 which can include indoor and outdoor educating activities
2. For small-scale business initiatives the following activity is going to be done.
 - Ms.Baigalmaa, RD officer of WWF, is going to meet the teachers and students who have business ideas and conduct training.